



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/223

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Макс майнд" ХХК Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.2.1, 20.2.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1 дэх заалтуудад заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор (Г.Гантөгс), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын захиалагчийн хяналтын инженер (Н.Ганболд)-д олгож аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож хэргийн шийдвэрлэлтийн талаар тухай бүр танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор (Г.Гантөгс), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын захиалагчийн хяналтын инженер (Н.Ганболд)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011451